

ЗӨВШӨӨРСӨН.
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ц.ЭРДЭМБИЛЭГ

Ц. Эрдэмбилэг



БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭХ БАРИХ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Д.МӨНХЦЭЦЭГ

ЭХ БАРИГЧИЙН “ЖИРЭМСЭН БА ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН
ЗӨВЛӨГЧ” МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР
(PREGNANCY AND POSTPARTUM MIDWIFE COUNSELLOR)

МЭРГЭШЛИЙН ИНДЕКС: (Ss)09130030
СУРГАЛТЫН ХУГАЦАА: 3 сар

УЛААНБААТАР
2022

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн хэвийн үйл явцыг дэмжиж улмаар эх, нярайн өвчлөл, эндэгдлээс сэргийлэхэд мэргэшсэн эх баригч гол үүрэгтэй. Эх баригчдын олон улсын нийгэмлэг /ЭБОУН/-ээс 2018 онд гаргасан “Эх барихуйн боловсролын даяар стандарт”-д эмэгтэйчүүд, нярай гэр бүлд чиглэсэн эрүүл мэндийн чанартай нотолгоонд түшиглэсэн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжсэн эх баригч бэлтгэх нь дэлхий даяар эх барихуйг бэхжүүлэх багана тулгуур болох юм гэж тодорхойлсон. Олон улсын стандартын дагуу сургагдсан эх баригч нь эмэгтэйчүүдэд үзүүлэх бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндсэн тусламжийн 87% -ийг гүйцэтгэх боломжтой бөгөөд аюулгүй, чанартай, соёлын мэдрэмжтэй тусламжийг үзүүлснээр эх, нярайн эндэгдэл ба амьгүй төрөлтийн 80% сэргийлэх боломжтой (НҮБ-ын ХАС, 2014; Renfrew et al., 2014; Homer et al., 2014).

Олон улсын эх баригчдын нийгэмлэгээс “Эх баригч мэргэжилтний практикт шаардагдах чадамж” баримт бичгийг 2019 онд шинэчлэн боловсруулсан бөгөөд энэхүү чадамжийн жирэмсэн ба төрсний дараах үеийн тусламж үзүүлэх чадамж бүлэгт хэвийн жирэмслэлттэй холбоотой мэдээллүүдийг эх, түүний гэр бүл хамтрагчид өгөх, хувь хүний хэрэгцээнд тохирсон мэдээллийг үнэн зөв ойлгомжтой хүргэх, эрүүл мэндийн зан үйлээ өөрчлөхөд нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, жирэмсний аюултай шинжийн талаар мэдээлэл өгөх; төрсөн эхэд өөрийгөө болон нярай хүүхдээ асрах, аюулгүй бэлгийн харьцаа, гэр бүл төлөвлөлт, нярайд хөхөөр хооллох, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх, төрсний дараах үед тохиолдож болзошгүй хүндрэл эрсдэлүүдийн тухай мэдээллээр хангана гэж тодорхойлсон байна. 2030 он хүртэлх Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд “Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж эх хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна гэсэн зорилтын хүрээнд эхийн эндэгдлийг 100 мянган амьд төрөлтөнд 15, нялхсын эндэгдлийн түвшнийг 1000 амьд төрөлтөнд 8 болгож бууруулахаар заасан. 2020 онд эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөнд 30.2 буюу дэлхийн дунджаас 7 дахин, бүсийн дунджаас 2 дахин цөөн; нярайн эндэгдэл бууруулах зорилтот түвшиндээ хүрсэн боловч бүсийн дунджаас 1.3-аар өндөр байна. Эхийн эндэгдлийн шалтгааны 39.1 хувь нь жирэмсний хүндрэл, 39.1% төрсний дараах хүндрэл тус тус эзэлж байна.

ДЭМБ-аас жирэмсний хяналтад 8 удаа хамрагдсан байхыг зөвлөмж болгодог бөгөөд манай улсад удаа 6 удаа, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзүүлэхийг зөвлөдөг бөгөөд эх жирэмсэн болсноо мэдмэгц 12 долоо хоногоос дотогш хугацаанд эхний үзлэгт хамрагдахыг зөвлөдөг. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс удаа хяналтын үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2020 оны байдлаар 78.8 хувь байгаа нь өмнөх оноос 2.8 хувиар буурсан үзүүлэлттэй байсан. ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж үздэг. Манай улсын хувьд 2020 оны байдлаар харьцангуй өндөр буюу

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН БАГ:

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төлөөлөл:

Х.Цэцэгсүрэн	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн ахлах багш, Анагаахын шинжлэх ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
Я.Оюунбилэг	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
П.Цэцэгмаа	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн ахлах багш, Сувилахуйн ухааны доктор, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
Б.Туул	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч;
Л.Туяацацрал	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаахын шинжлэх ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч;
С.Сэржням	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр;

Сургалт эрхлэх байгууллагын төлөөлөл:

С.Түмэнжаргал	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн арга зүйч, тэргүүлэх зэргийн эх баригч;
С.Даваасүрэн	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, Сувилахуйн ухааны магистр, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн тэргүүн;
Д.Уламбаяр	Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны арга зүйч, Зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
Ч.Бурмаа	Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;

- М.Мөнхөө Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сувилахуйн албаны арга зүйч, тэргүүлэх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
- Д.Насантогтох Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ахлах эх баригч, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;

Зөвлөх багийн төлөөлөл:

- Икэмото Мэгүми Сувилахуйн ухааны доктор, ЖАЙКА Олон улсын байгууллагын “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн эх баригчийн сургалт хариуцсан мэргэжилтэн,

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

- Б.Туяа Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн;
- Д.Дондогмаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр;
- Д.Энхтуяа Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэргэжил Дээшлүүлэх Институтийн Сувилахуйн төгсөлтийн дараах сургалт хариуцсан ахлах арга зүйч, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга;

ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАСАН:

- П.Эрхэмбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дэд дарга, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагч;

26.4 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Иймд жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн тусламж үзүүлэх багт хамтран ажилладаг эх баригч мэргэжилтэн нь жирэмслэлт, төрсний дараах үеийг хэвийн явагдахад үр дүнтэй мэргэжлийн зөвлөгөө өгөхөд мэргэших шаардлагатай байна.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Жирэмсэн эмэгтэй, төрсөн эх болон түүний гэр бүлд жирэмслэлт, төрсний дараах үеийн нэн шаардлагатай зөвлөгөөг хэрэгцээнд нь нийцүүлэн өгөх мэдлэг, ур чадвар, мэргэжлийн ёс зүй, хандлагыг цогцоор нь дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Жирэмсэн ба төрсний дараах үеийн зөвлөгч эх баригчийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эх баригчийн дүр зураг:

ЖИРЭМСЭН БА ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН ЗӨВЛӨГЧ ЭХ БАРИГЧ нь жирэмсэн ба төрсний дараах үед жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд өөрийнхөө болон ургийн, нярайн эрүүл мэнд сайн сайхан байдлыг хадгалан бэхжүүлэхэд нь зөвлөн дэмжлэг үзүүлэх, хэвийн бус байдлыг эрт илрүүлэх **МЭРГЭШСЭН ЭХ БАРИГЧ МЭРГЭЖИЛТЭН** юм. Мөн түүнчлэн мэргэшсэн эх баригч мэргэжилтэн нь тухайн суралцсан мэргэшлийн чиглэлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад тулгуурлан эх барихуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхээс гадна эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахын тулд бусад эх баригч мэргэжилтнүүдэд заан чиглүүлэх, зөвлөн туслах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон нийгмийн халамжийн чиглэлээр холбогдох байгууллага болон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

Хөтөлбөрийн зорилтын хүрээнд мэргэшлийн дараах цогц чадамжийг эзэмшинэ. Үүнд:

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цогц чадамжтай байна.

Монгол улсад мөрдөж байгаа хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэх, ажил олгогч нарын хэрэгцээг хангахын зэрэгцээ олон улсын чиг хандлагад нийцсэн мэдлэг, чадвар, чадамжтай мэргэжилтэн бэлтгэх зорилтын хүрээнд дараах мэргэшлийн цогц чадамжийг эзэмшинэ.

1. Жирэмсэн үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж

- Жирэмсэн эмэгтэй болон ургийн биеийн байдлыг үнэлж тодорхойлох
- Жирэмсэн эмэгтэйд мэргэжлийн тусламж үзүүлэх
- Эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх
- Жирэмсэн эмэгтэйн сэтгэл зүй, бие махбод, физиологийн хэрэгцээнд тохирсон үр дүнтэй зөвлөгөө өгөх
- Жирэмсэн эмэгтэй, түүний ургийн аюулгүй байдлыг хангахад туслах

2. Төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж

- Төрсөн эх, нярайн эрүүл мэнд биеийн байдлыг үнэлж тодорхойлох
- Эх хүүхдийн холбоо харилцааг сайжруулах, эхийн биеийг тэнхрэхэд нь туслах

- Төрсөн эх болон нярайн бие махбод, физиологийн хэрэгцээ, сэтгэл зүйд тохирсон үр дүнтэй зөвлөгөө өгөх
- Нярайн өсөлт хөгжилтийг үнэлж, эрүүл бойжиход туслан дэмжих
- Төрсөн эх, нярайн аюулгүй байдлыг хангахад туслах
- Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн хэвийн явцыг хангаж хэвийн
- Жирэмслэлт, төрөлтийн тоог нэмэгдүүлэх;
- Жирэмслэлт төрсний дараах үеийн хүндрэлээс сэргийлэх;
- Эх, ураг, нярайн өвчлөл ба эндэгдлийг бууруулах;
- Кесар хагалгааны давтамжийг бууруулах;
- Олон улсын эх баригчийн боловсролын стандарт, практик чадамжид нийцэхүйц эх баригчдын бие даасан зөвлөгөө өгөх кабинетуудыг ажиллуулах

3. Мэргэжлийн хувьд бие даасан байх

- Бие даасан үйл ажиллагаа явуулах ба бусад эрүүл мэндийн тусламж үзүүлэгчидтэй хамтран ажиллах, шаардлагатай үед нийгмийн үйлчилгээнд оролцох
- Жирэмсэн ба төрөгч эмэгтэй, түүний өсөн хөгжиж буй ураг, төрсөн ба түүний нярай хүүхдийг эрүүл энх байлгах, үндсэн тусламж үзүүлэхийн тулд оновчтой шийдвэр гаргаж чаддаг байх
- Эмэгтэй хүн жирэмсэлж, төрөх, өөрийгөө арчлах болон хүүхдээ асран өсгөхөд мэдлэг, ур чадвараа зориулахын зэрэгцээ эмэгтэй, түүний хүүхдийн сайн сайхны төлөө үзүүлж буй үйлчилгээндээ хариуцлагатай хандаж, хариуцлагаа хүлээдэг байх

4. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дэргэдэх халуун дулаан харилцагч байх

- Эмэгтэй болон түүний сонгосон дэмжлэг үзүүлэгч хүмүүст цаг ямагт тусламж өгч, харилцан холбоотойгоор хамтран ажиллах
- Хүнлэг энэрэнгүй, тусч, үнэнч шударга байж нэр төр, үзэл бодол, соёл, заншлыг нь хүндэтгэн тэгш үл ялгаварлаж харьцах
- Эмэгтэй, түүний гэр бүлтэй зөв боловсон зөв харилцах
- Харилцаанд гадаад болон зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байх

Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүн

Хөтөлбөрийн төгсгөлд Эх барихуйн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах үйл ажиллагааг манлайлан, бие даан ажиллах чадвартай, зөвлөгөө өгөх мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн эзэмшсэн ёс зүйг эрхэмлэсэн мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэгдэнэ.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

1. Жирэмсэн эмэгтэйн эрүүл мэндийг хамгаалж, жирэмслэлтийн хэвийн явцад дэмжлэг үзүүлэх;
2. Төрсөн эх, нярайн эрүүл мэндийг хамгаалж, тэдний хэвийн сайн сайхан байдалд дэмжлэг үзүүлэх;

3. Жирэмсэн, төрсөн эмэгтэй, нярай тэдний гэр бүлд хүндэтгэлтэй, ээлтэй үйлчилгээ үзүүлснээр эмэгтэйд эерэг туршлагыг бий болгох;
4. Жирэмсэн эмэгтэй ба ураг, төрсөн эх ба нярайг хүндрэл, өвчлөл, эндэгдлээс сэргийлэх;
5. Хүндрэлийг эрт илрүүлэх, эхний арга хэмжээг авч дараачийн тусламжид шилжүүлэх;
6. Шаардлагатай үед эх барихын яаралтай тусламж үзүүлж амь насыг аврах;

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй сургалтын технологид тулгуурлан суралцагчийн бие даах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байна.

Ажлын байрны сургалт (On-the Job Training)

Аргачлал	Суралцагч эх баригчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/ Хэрэглэгдэх хүүн	Удирдагч, хамтрагч
Жирэмсэн эмэгтэйн эрүүл мэндийг дэмжих, тулгарч болох асуудлууд ба жирэмсэн эмэгтэйд төрөлтөнд бэлтгэх зөвлөгөө	3	09:00-16:00 6 цагаар 7 хоногт 5 удаа	Жирэмсний хяналтын кабинет /Дүүрэг, БОЭТ, Амаржих газар/	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш
Төрсөн эх, нярайн эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө	3	09:00-17:00 8 цаг 7 хоногт 5 удаа	Амаржих газар/БОЭТ	Үйлчлүүлэгч	Эмнэл зүйн сургагч багш

Танхимын сургалт (Off-the Job Training)

Тойролт	Сургалтын хэлбэр	Суралцагчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/ Хэрэглэгдэх хүүн	Удирдагч, хамтрагч
Тойролт №1. Жирэмсэн эмэгтэйн эрүүл мэндийг дэмжих, тулгарч болох асуудлууд ба жирэмсэн эмэгтэйд төрөлтөнд бэлтгэх зөвлөгөө	Лекц	10 хүртэл	7 хоногт 3 удаа 2 цагаар 2 долоо хоног	Сургалтын анги танхим	Слайд, проектор	Сургагч багш, хамтран суралцагч
	Семинар	10 хүртэл	7 хоногт 2 удаа	Сургалтын анги	Слайд, проектор	Сургагч багш,

			4 цагаар 4 долоо хоног	танхим	Гарын авлага	хамтран суралцаг ч
	Бие даалт		Тохиромжт ой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцаг ч
Тойролт №2. Төрсөн эх, нярайн эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө	Лекц	10 хүртэл	7 хоногт 3 удаа 2 цагаар 2 долоо хоног	Сургалтын анги танхим	Слайд, проектор	Сургагч багш, хамтран суралцаг ч
	Семинар	10 хүртэл	7 хоногт 2 удаа 4 цагаар 3 долоо хоног	Сургалтын анги танхим	Слайд, проектор Гарын авлага	Сургагч багш, хамтран суралцаг ч
	Бие даалт		Тохиромжт ой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцаг ч
Тойролт №3. Яаралтай амилуулах суурь тусламж үзүүлэх зарчим	Лекц	10 хүртэл	7 хоногт 2-3 удаа 2 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор	Сургагч багш, хамтран суралцаг ч
	Семинар	10 хүртэл	7 хоногт 3 удаа 4 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор Гарын авлага	Сургагч багш, хамтран суралцаг ч
	Бие даалт		Тохиромжт ой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцаг ч

Бие даан суралцах агуулга (Self-Development Training)

- Эрүүл мэндийн боловсрол олгох арга зүй
- Харилцааны ур чадвар
- Үр дүнтэй харилцаа, зөвлөгөөний зарчим
- Эх барихуйн тусламж, эх баригчийн ёс зүйн хэм хэмжээ
- Жирэмсэн үеийн физиологи
- Жирэмсэн эх, ургийн хэрэгцээ
- Жирэмсэн эмэгтэйд үзлэг хийх
- Хоол шим судлал
- Нярай үеийн онцлог, физиологи
- Төрсөн эх, нярайн хэрэгцээ

- Төрсөн эх, нярайд үзлэг хийх
- Жирэмсэн эмэгтэй, ураг, төрсөн эх, нярайд эмийн зөв хэрэглээ ба нөлөө

ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА

Тойролт 1. Жирэмсэн эмэгтэйн эрүүл мэндийг дэмжих, тулгарч болох асуудлууд ба жирэмсэн эмэгтэйг төрөлтөнд бэлтгэх зөвлөгөө

- Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага, ёс зүй
- Мэргэшсэн эх баригчийн үүрэг хариуцлага
- Эх баригч мэргэжилтний удирдлага манлайлал, менежментийн үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн зөвлөгөө ба зааварчилгаа өгөх зарчим, аргууд
- Хувь хүнд чиглэсэн зөвлөгөө өгөх онцлог, арга
- Бүлгийн зөвлөгөө өгөх онцлог, арга
- Жирэмслэлтийн тусламж үзүүлэхтэй холбогдсон ОУ-ын зөвлөмж
- Жирэмслэлтийн тусламж болон ЭМ-ийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон МУ-ын хууль тогтоомжууд, ЭМЯ-ны сайдын тушаал, дүрэм журам, заавар
- Жирэмсэн эмэгтэйгээс асуумж авч, үнэлгээ өгөх
- Жирэмсэн эмэгтэйд биеийн үзлэг хийж, үнэлгээ өгөх
- Жирэмсэн эмэгтэйд эх барихуйн үзлэг хийж, үнэлгээ өгөх
- Жирэмсэн эмэгтэйн асуумж, үзлэгийн мэдээллүүдийг нэгтгэн дүгнэж үнэлгээ хийх
- Жирэмсний хяналт, түүний ач холбогдол, гэр бүлийн үүрэг оролцоог идэвхжүүлэх
- Хувь хүн эрүүл мэнддээ анхаарах нь, өөрийн асаргаа, хяналт
- Ургийн хөдөлгөөнийг хянах
- Жирэмсэн үеийн зөв хооллолтын дэглэм, ач холбогдол
- Жирэмсэн үеийн дасгал хөдөлгөөн, түүний ач холбогдол
- Амны хөндийн эрүүл мэнд
- Жирэмсэн үеийн бэлгийн харьцаа
- Тамхи ба хорт зуршлын нөлөө, түүнээс сэргийлэх, зан үйлийг өөрчлөх загвар
- Жирэмсэн үеийн эмийн хэрэглээ, түүний нөлөө, төмөр ба бичил элементийн ач холбогдол
- Жирэмсэн эмэгтэйг сэтгэл зүйн хямрал өөрчлөлтөөс хамгаалах
- Жирэмсэн үеийн сэтгэл зүйн хямралыг илрүүлэх, зөвлөгөө өгөх
- Пренатал илрүүлэг, оношилгоо, ач холбогдол
- Жирэмсний аюултай шинж тэмдэг
- Жирэмслэлтэд эрхтэн тогтолцооны эмгэг нөлөөлөх тухай ойлголт, хүндрэлээс сэргийлэх
- Зулбалт, дутуу төрөхөөс сэргийлэх
- Манас таталтын урьдлаас сэргийлэх
- Жирэмсэн эмэгтэйн амьдралын хэв маягийн зөвлөмж
- Дотор муухайрах, огьж бөөлжих буюу эрт үеийн хордлогын зөвлөмж
- Нуруу чилэх, нуруугаар өвдөх, умдаг орчим хөндүүрлэх үеийн зөвлөмж
- Ядарч сульдах болон нойрны хямралын үеийн зөвлөмж

- Судас бүдүүрэх, шээс дусагнах, хавагнах үеийн зөвлөмж
- Өтгөн хатах, гэдэс дүүрэх үеийн зөвлөмж
- Төрөлтийн үйл ажиллагаа, төрөлтөнд бэлтгэх, идэвхтэй төрөлт
- Төрөлтийн хамтрагчийн дэмжлэг, ач холбогдол
- Төрөлтийн үеийн өвдөлтийн мэдрэмжийг эмийн бус бууруулах аргууд
- Нярайн нэн шаардлагатай тусламж, анхны тэврэлт

Тойролт 2. Төрсөн эх, нярайн эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө

- Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах тусламж үзүүлэхтэй холбогдсон ОУ-ын зөвлөмж
- Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах тусламж болон ЭМ-ийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон МУ-ын хууль тогтоомжууд, ЭМЯ-ны сайдын тушаал, дүрэм журам, заавар
- Төрсөн эхээс асуумж авч, үнэлгээ өгөх
- Төрсөн эхэд биеийн үзлэг хийж, үнэлгээ өгөх
- Төрсөн эхэд эх барихуйн үзлэг хийж, үнэлгээ өгөх
- Төрсөн эхийн асуумж, үзлэгийн мэдээллүүдийг нэгтгэн дүгнэж үнэлгээ хийх
- Эрүүл нярайд үзлэг хийх, асуудлыг илрүүлэх
- Эхийн асуумж ба үзлэгийн үр дүнд нярайн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгч нэгтгэн дүгнэх
- Төрсөн эх, нярайн гэрийн эргэлт, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх
- Төрсөн эмэгтэйн амьдралын хэв маягийн зөвлөмж
- Хөхүүл, хөхүүл биш төрсөн эхийн зөв хооллолт
- Төрсний дараах үеийн дасгал, түүний ач холбогдол
- Төрсөн эхийн сэтгэл хөдлөл, сэтгэл зүйн эрүүл мэндийн зөвлөгөө (хүүхдээ алдсан, хүндрэлтэй төрсөн) ба сэтгэл гутралыг илрүүлэх илрүүлэх, зөвлөгөө өгөх ба сэтгэцийн мэргэжилтэнд шилжүүлэх
- Төрсний дараах бэлэг эрхтэн, шархны болон аарцгийн арчилгаа
- Төрсөн эх, нярайд эмийн нөлөө, зөв хэрэглээ
- Эх нярай хүүхдээ ажиглах, эрүүл нярайн асаргааны зөвлөмж
- Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг үр өгөөжтэй ашиглах

Тойролт 3. Яаралтай амилуулах суурь тусламж үзүүлэх зарчим

- Эмнэлгийн мэргэжилтний халдварын сэргийлэлт, хяналт
- Мэргэшсэн эх баригчийн үүрэг хариуцлага
- Эхэд үзүүлэх яаралтай тусламж
- Нярайн зүрх уушгины амилуулах тусламж
- Амилуулах суурь тусламж
- Амилуулах лавшруулсан суурь тусламж
- Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ, лавшруулсан тусламж

ТОЙРОЛТЫН СУРГАЛТЫН ХЭЛБЭР

№	Тойролтын нэр	Тойролтын хугацаа /7 хоногоор/	Тойролт хийх байгууллага
1.	Тойролт-1. Жирэмсэн эмэгтэйн эрүүл мэндийг дэмжих, тулгарч болох асуудлууд ба жирэмсэн эмэгтэйг төрөлтөнд бэлтгэх зөвлөгөө	6	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага
2.	Тойролт-2. Төрсөн эх, нярайн эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө	5	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага
3.	Тойролт-3. Яаралтай амилуулах суурь тусламж үзүүлэх зарчим	1	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага

ДОЛОО. СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

Суралцагч ба хариуцагч

Сургалтын 3 сарын хугацаанд суралцагч бүрийн ахиц дэвшлийн талаар зөвлөгөө өгөх, суралцагчийн хувийн төлөвлөгөөний талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах мэргэжилтнийг (цаашид "хариуцагч" гэх) оноож хуваарилна. Суралцагч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид сард 2-3 удаа уулзаж ярилцан үнэлгээтэйгээ танилцан эргэн зөвлөгөө авна.

Суралцагч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагчид тойролт бүрт сургагч багшийг хуваарилах бөгөөд сургагч багштайгаа хамтран ажиллана.

- Тойролт эхлэхээс өмнө сургалтын зорилгын талаар ярилцана.
- Зорилтдоо хүрэхэд шаардлагатай асуудлууд, арга хэмжээний талаар хэлэлцэнэ.
- Сургалтын явц, төгсгөлд багштай ярилцаж сургалттай холбоотой санал, сургалтын үр дүнгийн талаар ярилцана.

Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн ур чадвар, сургалтын үр дүнтэй холбоотой ахиц дэвшил, амжилтыг хэмжих боломжийг олгосон ажлын байранд илүү суурилсан үнэлгээ байна. Суралцагч сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн кредит цагийг биелүүлсэн байна. Онол, дадлага, бие даалт, семинарын хичээлүүдийн үнэлгээ тус бүрээр авсан рейтинг оноо 80% ба түүнээс дээш тохиолдолд үнэлгээг тооцох ба түүнээс доогуур үнэлгээ авсан тохиолдолд журмын дагуу дахин шалгалтыг товлосон хугацаанд өгч тооцуулна.

Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace-based Assessment)

Суралцагч эх баригчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээг сургалтын өмнө, явцад, дараа тус тус үнэлнэ.

360 хэмийн үнэлгээ:

Суралцагч мэргэжлийн байх (professionalism) болон зохион байгуулагч, манлайлагч (leader) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 3 сарын сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан сургагч багш, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг нийт 3 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Сорилын шалгалт:

Сургалтын агуулгын хүрээнд олон болон нэг сонголттой сорилоор тойролт бүрийн төгсгөлд шалгалт авна.

Бодлого шалгалт:

Боловсруулсан эмнэлзүйн тохиолдол дээр суралцагчийг ажиллуулж үнэлнэ.

Портфолио:

Суралцагч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, дадлага, бие даалт, хичээлийн материалыг үр дүн болгож хадгалах.

Үнэлгээний дүнг хянах:

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж хадгална. Үнэлгээний дүнг хариуцагч болон суралцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхаарна.
- Тест, тохиолдлын үнэлгээний дүнг суралцагчид танилцуулж, хадгална.
- Суралцагч бүрийн Портфолиод үнэлгээ болон сургагч багштай зөвлөлдсөн зүйлсийн агуулгыг бичиж тэмдэглэх, хадгалах хэрэгтэй.
- Үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулж, сургалтыг төгсгөх үед суралцагчид хариуцагчаас эргэн зөвлөгөө өгнө.

Төгсөлтийн шалгалт:

Сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Хөтөлбөрийн шаардлагыг 80%-аас дээш хувь хангасан тохиолдолд төгсөлтийн шалгалтад оруулна. Төгсөлтийн шалгалтыг онол, дадлага хэлбэрээр авах бөгөөд онолын шалгалтыг сорил, бодлого хэлбэрээр; ур чадвар болон хандлагын шалгалтыг сургалтын явц болон төгсгөлд эмнэлзүйд ажилласан, гардан үйлдэл хийх гүйцэтгэлээр үнэлнэ. Шалгалтад тэнцсэн тохиолдолд мэргэшлийн үнэмлэх олгоно.

Сургалтыг төгсгөхийг шийдвэрлэх

Тойролт бүрийг дуусах үед хийгдсэн үнэлгээний дүнг нэгтгэж сургалт эрхлэх байгууллага, сургалтын алба, сургагч багш тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг гаргана. Сургалт дуусах үед 360 хэмийн үнэлгээ, сорил, тохиолдлын

үнэлгээ, үнэлгээний дүн, портфолио үнэлгээ, сургалтын ирцийг харгалзан үзэж сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Шийдвэр гаргах шалгуур:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц
- Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- 3 сарын хугацаанд тойролт бүрийн лекц, дадлага, зайлшгүй судлах бие даалтын агуулгын 80%-аас доошгүйг үзэж туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл сургалтын 2 дахь сарын эцэст төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ БА ХЯНАЛТ

Сургалтын хяналтын зөвлөл

Сургалтын хяналтын зөвлөл нь Сургалт эрхлэх байгууллагын даргын шууд удирдлага доор ажиллана:

- Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд 1 удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагчтай холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхийг зорьдог байна.

Хөтөлбөрийн хяналт:

- Сургалтын алба нь хөтөлбөрийн хяналтыг хийнэ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагчийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын албаны мэргэжилтэн хариуцан сургалтын хяналтын зөвлөлд оруулан хэлэлцүүлж өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

Сургалтын танилцуулга (Orientation)

Сургалт эхлэхийн өмнө сургалтын төлөвлөгөө (program) болон хөтөлбөрийн (curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагааны тухай, халдвар хамгаалал, ёс зүйн тухай суралцагчид ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч, сургагч багшийг ажигласны үндсэн дээр (бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус)

суралцагч эх баригчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

Үнэлгээ хийсэнонсарөдөр

Суралцагчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш, Эмч, Эх баригч, Тасаг, нэгжийн эрхлэгч, Тасаг, нэгжийн ахлах арга зүйч, Бусад _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Хяналтын кабинет, ӨЭМТ, Амбулатори, Тасаг

Суралцагчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш, Сувилагч, Бусад _____

Суралцагчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эх баригчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор (<19%)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (>80%)

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлгийн ажилтантай харилцах хандлага: хүндэтгэлтэй, харилцан ойлголцож харилцаж байгаа байдал	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үйлчлүүлэгчтэй харилцах хандлага: итгэл найдвартай, үйлчлүүлэгчдийн эрх болон хийх эрхийг хүндэтгэн үздэг эсэх	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Найдвартай нягт нямбай байдал	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Харилцааны ур чадвар: Үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлтэй харилцах	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Багаар ажиллах ур чадвар: хариуцлагатай, шуурхай, нэгнээ дэмжих байдал	<input type="checkbox"/> ИА	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

Харилцааны ур чадвар: эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай харилцах	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Манлайлах ур чадвар: өөрийн болоод багийн хийж буй ажилд хариуцлагатай, идэвхтэй оролцох	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Ерөнхий харилцаа, хандлагын байдал	<input type="checkbox"/> IA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг	<input type="checkbox"/> IA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: "Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эх баригчид хэрэг болох уу?"

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-CEX ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Эмнэлзүйн ур чадварын үнэлгээ (Mini-CEX)

Энэхүү үнэлгээ нь: эмнэлзүйн ярилцлага болон үзлэг хийх үед суралцагчийн ярилцлага, бодит үзлэг хийх ур чадвар, эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, зөвлөгөө өгөх, зохион байгуулах зэрэг цогц чадамжийг нэгэн зэрэг 9 онооны системээр үнэлдэг.

Үнэлгээ хийсэнонсарөдөр

Суралцагчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш, Эмч, Бусад _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Хяналтын кабинет, ӨЭМТ, Амбулатори, Тасаг

Бусад _____ Үйлчлүүлэгчийн нас: _____ Үйлчлүүлэгчийн хүйс: Эм

Үзлэг(доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал (доогуур нь зур): жирэмсэн эмэгтэй, төрсөн эх, нярай, түүний ар гэр бүл

Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж: Жирэмсэн эмэгтэйдгээс асуумж авах Жирэмсэн эмэгтэйд биеийн ерөнхий үзлэг хийх Жирэмсэн эмэгтэйд эх барихын үзлэг хийх Жирэмсэн эмэгтэйд зөвлөгөө өгөх Төрсөн эхээс асуумж авах Төрсөн эхэд биеийн ерөнхий үзлэг хийх Төрсөн эхэд эх барихын үзлэг хийх Төрсөн эх, түүний гэр бүлд

зөвлөгөө өгөх Төрсөн эхээс нярайн биеийн байдлын талаар асуумж авах Нярай хүүхдэд үзлэг хийх Төрсөн эхэд нярай хүүхдээ асрах талаар зөвлөгөө өгөх Бусад

1. Асуумж авах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
2. Бодит үзлэг хийх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
3. Эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
4. Зөвлөгөө өгөх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
5. Үр дүнтэй зохион байгуулах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
6. Үйлчлүүлэгчид тавьж буй анхаарал, хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
7. Ерөнхий эмнэлзүйн ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

Үнэлэгчээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж: (1-9 оноог өгнө)

Суралцагчаас Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж: (1-9 оноог өгнө)

Тэмдэглэл:

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал
-------------	--------------------------------	-------------

--	--	--

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагчийн гарын үсэг: _____

Хавсралт 3

Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалтын (DOPS) үнэлгээ

Энэхүү гардан үйлдлийн үнэлгээ нь: эмнэлгийн нөхцөлд хийгддэг ажилбарыг ажиглах замаар үнэлж дүгнэдэг арга юм. Өвчтөний дэргэд эсвэл эмнэлзүйн дуураймал орчинд шалгуулагчийн техник ур чадварыг 15-25 минутын хугацаанд 9 онооны системээр үнэлдэг.

Үнэлгээ хийсэнонсарөдөр

Суралцагчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш, Эмч, Бусад _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Хяналтын кабинет, ӨЭМТ, Амбулатори, Тасаг

Бусад _____ Үйлчлүүлэгчийн нас: _____ Үйлчлүүлэгчийн хүйс: Эм

Үзлэг(доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал (доогуур нь зур): жирэмсэн эмэгтэй, төрсөн эх, нярай, түүний гэр бүл

Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж: Жирэмсэн эмэгтэйгээс асуумж авах Жирэмсэн эмэгтэйд биеийн ерөнхий үзлэг хийх Жирэмсэн эмэгтэйд эх барихын үзлэг хийх Жирэмсэн эмэгтэйд зөвлөгөө өгөх Төрсөн эхээс асуумж авах Төрсөн эхэд биеийн ерөнхий үзлэг хийх Төрсөн эхэд эх барихын үзлэг хийх Төрсөн эх, түүний гэр бүлд зөвлөгөө өгөх Төрсөн эхээс нярайн биеийн байдлын талаар асуумж авах Нярай хүүхдэд үзлэг хийх Төрсөн эхэд нярай хүүхдээ асрах талаар зөвлөгөө өгөх Бусад _____

1.Хийж буй үйлдлийн техник болоод холбогдох ойлголтуудыг мэдэж буй байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
2.Үйлчлүүлэгчээс холбогдох зөвшөөрлийг авсан эсэх (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
3.Гардан үйлдлийн өмнөх бэлтгэл ажил (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

4.Жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд өөрийнхөө болон ургийн, нярайн эрүүл мэндийн талаар зөвлөгөөг сонгон өгч байгаа байдал								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
5.Техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
6.Халдваргүйжүүлэх техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
7.Зөв зохистой тусламж үйлчилгээ, зөвлөгөөг өгөх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
8.Гардан үйлдлийн дараах менежмент (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
9.Харилцааны ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
10.Үйлчлүүлэгчид тавьж буй анхаарал ба хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		
11.Үйлдлийг гүйцэтгэх ерөнхий ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)								
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй			Хангалттай			Маш сайн		

Үнэлэгчээс DOPS үнэлгээнд өгөх сэтгэл ханамж: (1-9 оноог өгнө)

Суралцагчаас DOPS үнэлгээнд өгөх сэтгэл ханамж: (1-9 оноог өгнө)

Тэмдэглэл:

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагчийн гарын үсэг: _____

АШИГЛАХ НОМ СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГА БУСАД

Холбогдох хууль тушаал, стандарт:

- Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль
- Монгол улсын Эрүүл мэндийн тусламжийн тухай хууль
- Эрүүл мэндийн сайдын 318 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 406 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 536 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 537 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 335 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 505 дугаар тушаал
- ЭМС-ын 216 дугаар тушаал
- Түгээмэл үйлдлийн стандарт MNS4621:2008.

Гарын авлага:

- “Жирэмсний хяналт ба тусламж”, П.Цэцэгмаа, Я.Оюунбилэг, Х.Цэцэгсүрэн. УБ.
- “Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах болон нярайн тусламж” сургалтын гарын авлага, ДЭМБ, НҮБ-ын ХАС, УБ. 2008 он.

Үндсэн сурах бичиг:

1. “Эх барих”, Т.Эрхэмбаатар, Ж.Энхцэцэг ба бусад. УБ. 2015 он.
2. “Эх барихуй”, Б.Жав. УБ. 2007 он.
3. “Эх барих”, Б.Шижирбаатар. УБ. 2007 он.
4. Williams Obstetrics, F.Gary Cunningham other, 2014, 24th edition
5. Varney’s Midwifery, second edition
6. “Харилцах ур чадварт суралцахуй”. С.Наранчимэг нарын, УБ. 2016 он. х.46-52
7. “Хандлагын нууцад нэвтрэх нь. С.Наранчимэг, УБ. 2009 он. х92-98
8. “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”. Д.Цэрэндагва, Б.Оюунгоо. УБ.2021 он

Ашиглах вейб сайтын хаягууд:

- www.healthline.com › Pregnancy › Healthy Pregnancy
- www.cdc.gov/pregnancy/during.htmlwww.jcapers-irsc.weebly.com
- www.healthline.com › Pregnancy › Healthy Pregnancy
- http://www.cdc.gov/ncidod/dhqp/gl_isolation_ptII.html